



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Нэгтгэн дүгнэх журмыг шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн жилийн ажлыг нэгтгэн дүгнэх хялбаршуулсан журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ш.Цэрэндулам)-т даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2017 оны "Нэгтгэн дүгнэх журмыг шинэчлэн батлах тухай" А/08, 2020 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/12 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2026 оны 08 дүгээр сарын 10-ны өдрийн
А/28 дугаар тушаалын хавсралт

**АЙМАГ, ХОТЫН УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВҮҮДИЙН ЖИЛИЙН АЖЛЫГ
НЭГТГЭН ДҮГНЭХ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРАМ**

1. Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн жилийн ажлыг ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажил /80 хувь/, удирдлага, зохион байгуулалт /10 хувь/, төсөв, санхүүгийн үйл ажиллагаа /10 хувь/ гэсэн 3 хэсэгт хувааж дүгнэнэ.

2. Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын дүнг дараах байдлаар Улсын сүлжээний газар нэгтгэн дүгнэнэ.

2.1 Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын дүнд Агентлагийн холбогдох газар, хэлтэс, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Нислэгийн цаг уурын төв, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн дүгнэсэн дүнг хамааруулна.

2.2 Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын дүнг Агентлагийн даргын 2023 оны А/257 дугаар тушаалаар баталсан "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлыг дүгнэх журам"-ын 2 дахь хэсэгт заасан нэр бүхий 10 үзүүлэлтийн дунджийг зууны хувиар гарган байр эзлүүлнэ.

2.3 Цаг агаарын урьдчилсан мэдээ, Нислэгт үйлчилсэн мэдээ, Ус судлал, Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны болон Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын дүнг тухайн үзүүлэлтийн улсын дундаж утгаар тооцон дүгнэнэ.

3. Удирдлага, зохион байгуулалт, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны дүнд аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын төсвийн төвлөрүүлэн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, санхүүгийн үйл ажиллагааны дүнг хамааруулна.

3.1. Удирдлага зохион байгуулалтыг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу дүгнэнэ.

3.2 Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны дүнг Агентлагийн төсөв, санхүү хариуцсан нэгжээс гаргасан 12 үзүүлэлт бүхий аргачлалын дагуу дүгнэнэ.

4. Оны тэргүүнээр шалгарсан нэгж, салбаруудад нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хүртэл хэмжээний мөнгөн шагналыг олгож болно.

----oOo----